



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/855

Мандалговь

Үр дүнгийн урамшуулал  
олгох тухай

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1, 2 дугаар зүйлийн 2.2, 2021 онд байгууллагын дарга нартай хамтран ажиллах гэрээний 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргаас агентлагуудын дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээний хавсралтаар батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг үндэслэн "А буюу Маш сайн", "В буюу Сайн" үнэлэгдсэн байгууллагын дарга нарт хавсралтын дагуу мөнгөн урамшууллыг үндсэн цалингаас тооцон олгосугай.

2. Үр дүнгийн урамшууллыг давхардуулахгүй, байгууллагын төсөвтөө багтаан олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210976